**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ**
**БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ**
**ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 12 өдөр Дугаар А/43 Арвайхээр сум

Төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээний журам, үнийн жишигт нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.4, 24.5, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1,16.5.2, Эрүүл мэндмйн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 11 дүгээр зүйлийн 11.1, 13 дугаар зүйлийн 13.1.9, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоол, Сангийн сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/А/118 дугаар төлбөртэй тусламж үйлчилгээний журам, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс иргэн, байгууллагад үзүүлэх Төлбөртэй болон нэмэлт тусдамж үйлчилгээний журам-ыг нэгдүгээр хавсралтаар, Жагсаалт төлбөрийн жишиг хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2.Журмыг хэрэгжүүлж тусламж үйлчилгээг чанартай тэгш хүртээмжтэй байхаар зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа), тасгийн эрхлэгч сувилахуйн арга зүйч нарт, тушаалын эрх зүйн нийцэлд хяналт тавьж, эрх зүйн зөвлөмж өгч ажиллахыг Хуулийн зөвлөх (Д.Анхбаяр)-т тус тус үүрэг болгосугай

3.Тусламж үйлчилгээний санхүүжилт орлогыг төсөвт төвлөрүүлж биелэлтийг улирал тутамд тооцож ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Д.Баянмөнх) Сургалт,хөгжил, бодлого, төлөвлөлт гүйцэтгэлийн албаны дарга (Д.Аззаяа), Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр) Эдийн засагч (Б.Цэрэндолгор) нарт даалгасугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан БОЭТ-ийн захирлын Төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээний журам батлах тухай 2023 оны 05 дугаар сарын 18-ны А/39 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ Г.ДАШЖАНЦАН

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн
Захирлын 2025 оны 11 дугаар сарын 12 өдрийн
А/43 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Хувилбарын дугаар: 02

Хүчин төгөлдөр болсон огноо: 2023-05-15

Баримт бичгийн дугаар

| | | | |
|---|---|---|---|
| **Баримт бичгийг хариуцах нэгж** | | | |
| **Баримт бичгийн нууцлалын зэрэглэл:** | **Дотоод** | **Баримт бичгийн түвшин** | **2** |
| | | **Албан тушаал** | **Гарын үсэг** |
| **Боловсруулсан:** | **Гүйцэтгэх удирдлагын баг** | ЭМТҮЧАБАлбаны дарга<br>Ц.Лувсандамдин<br>Ерөнхий санхүүч<br>Г.Ганчөдөр | |
| **Санал өгсөн хянасан:** | **Гүйцэтгэх удирдлагын баг** | Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Д.Болормаа<br>Гүйцэтгэлийн удирдлага дотоод хяналтын баг Д.Аззаяа<br>Поликлиникийн эрхлэгч<br>Д.Цэцэгтуяа | |
| **Хянаж батласан:** | | БОЭТ-ийн захирал | |

**Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл**

| **Хувилбарын дугаар** | **Хүчин төгөлдөр болсон огноо** | **Өөрчлөлтийг батласан албан тушаалтан** | **Өөрчлөлтийн утга**<br>(баримт бичигт ямар өөрчлөлт орсоныг товч тайлбарлана) |
|---|---|---|---|
| 1 | 2023.05.16 | | Баримт бичгийн анхны хувилбар |
| 2 | 2025.11.10 | | Нэмэлт өөрчлөлт оруулав. |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

**АГУУЛГА**


1. ЗОРИЛГО ........................................ 4

2. ХАМРАХ ХҮРЭЭ ........................................ 4

3. НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГ. ........................................ 4

4. ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД ........................................5

5. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ЭРХ МЭДЭЭЛЭЛ ........................................ 5

6. ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ ........................................6

7. ТӨЛБӨРТЭЙ БОЛОН НЭМЭЛТ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОЛСОН ОРЛОГЫН БҮРТГЭЛ, ЗАРЦУУЛАЛТ. ........................................6

8. ХОРИГЛОХ ЗҮЙЛ ........................................ 7-8

9. ХЯНАЛТ. ........................................ 9

10. ХАРИУЦЛАГА. ........................................ 9

11. БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВӨӨС ИРГЭНД ҮЗҮҮЛЭХ ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ЖИШИГ ХЭМЖЭЭ .... 9-32

12. ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ХӨТЛӨХ МАЯГТ ............... 33

## НЭГ. ЗОРИЛГО

БОЭТ-өөс иргэдэд хүргэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай аюулгүй хүргэхэд оршино.

## ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ :

БОЭТөвийн нийт эмч эмнэлгийн мэргэжилтэн, БОЭТ-өөс эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байгаа аж ахуй нэгж байгууллага иргэд дагаж мөрдөнө.

## ГУРАВ. НЭР ТОМЪЁО, ТОВЧИЛСОН ҮГС, ИШ ТАТСАН БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

### 3.1 НЭР ТОМЬЁО:

- БОЭТ-бүсийн оношилгоо эмчилгээний төв
- AFP-Элэгний хавдрын шинжилгээ
- PSA-Түрүү булчирхайн хавдрын шинжилгээ
- CEA -Бүдүүн шулуун гэдэс, ходоодны хавдрын шинжилгээ
- CA 72-4 - Хоол боловсруулах эрхтэний болон эмэгтэйчүүдийн хавдрын шинжилгээ
- CA 125 - Өндгөвчний хавдрын шинжилгээ
- CA 153 - Хөхний хавдрын шинжилгээ
- NSE - Уушгины хавдрын шинжилгээ
- Спирограмм- Уушигны амьдралын багтаамж шалгах
- Ларингоскопия- Төвөнхийн дуран
- Маммографи - Хөхний рентгэн зураг
- PSG -Нойрны олон үйлдэлт бичлэг
- Тимпанометр- Дунд чихний үйл ажиллагааг шинжлэх арга
- Transforaminal steroid injection-Нурууны мэдрэл гарах хэсэгт дааврын тарилга хийх
- Нируха- Зөөлөн шимт
- Ханиур - Биеэс муу цусыг ялгаж гадагшлуулах
- Самнуур- Биеэс муу шар усыг гадагшлуулах
- Түрэм- Алт мөнгөн зүүгээр эмчилгээ хийх
- anti-A титр- Альфа эсрэг биеийн титр
- anti-B титр- Бетта эсрэг биеийн титр
- Кумбсын урвалж - Хүний глобулины эсрэгбие агуулсан ийлдэс
- ЭМБ-Эрүүл мэндийн байгууллага
- Код- тусламж үйлчилгээ бүрийг таних тусгай дугаар

## 3.2 ХОЛБОГДОЛТОЙ БУЮУ ИШ ТАТСАН БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламжийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- ISO 9001:2015 ЧУТ-ны стандарт
- Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 5095:2017 стандарт
- Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дугаар тушаал
- “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн” 2022 оны 01 дүгээр тогтоол
- “Сангийн сайд”, “Эрүүл мэндийн сайдын” хамтарсан 2022 оны 49/A/118 дугаар тушаал
- Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн A/216 дугаар тушаал
- Эрүүл мэндийн сайдын 2017 оны A/145 дугаар тушаал

## ДӨРӨВ. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА (RACI матриц)

Хүснэгт1- Процессын үүрэг хариуцлагын матриц

| **Процесс** | Удирдлагын баг | Эмч нар | Эмнэлгийн ажилчид | Сувилагч | Цахим бүртгэлийн ажилтан | Хөтөч сувилагч | Кассын нярав | Гүйцэтгэлийн удирдлага дотоод аудит | ЭТҮЧАБАлба | Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Эмч, цахим бүртгэлийн ажилтан, хөтөч төлбөртэй тусламж үйлчилгээний мэдээлэл хүргэнэ | ACI | RA CI | CI | CI | CI | CI | ACI | ACI | CI | ACI |
| 2. Төлбөртэй тусламж үйлчилгээний хуудас хөтлөх | | R | R | | | | C | | C | C |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3. Кассанд тусламж үйлчилгээний трифыг тушаах | IC | C | | I | C | I | R | C | C | C |
| 4. Төлбөртэй тусламж үйлчилгээг чанартай аюулгүй үзүүлэх | C | AR | CI | CI | I | I | C | AC | A C | AC |
| 5.Тусламж үйлчилгээний орлого трифын тодорхой хувийг буцаан олголт хийх | RA | CI | CI | CI | I | I | CI | RA | C | C |
| 6. Аж ахуй нэгж байгууллагатай урьдчилсан гэрээ хийх, төлөвлөлт хийх | RA | I | I | I | I | I | RA | RC | C | AC |

(R- гүйцэтгэх, A- хариуцах, C- хамтран ажиллах, I-мэдээлэлтэй байх)

## ТАВ. ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЗАРЧИМ

5.1 Энэхүү журмаар Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвөөс Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тус тус заасан улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж үйлчилгээний багцад ороогүй тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

5.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өөрийн хүсэлтээр авах тусламж, үйлчилгээний төлбөрийг хоёрдугаар хавсралтанд заасан тарифын дагуу иргэн өөрөө хариуцна.

5.3 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын архаг тусламж үйлчилгээнд хамрагдах оношийн хамааралтай бүлгийг даатгалаас санхүүжүүлдэг бодит зардлаар тооцон төлбөрийг төлнө.

5.4 Тус журам нь эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолуудын өөрчлөлт болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилттай уялдан нэмэлт өөрчлөлт орж болох ба тухайн үед захирлын тушаалаар баталгаажна.

## ЗУРГАА. ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

6.1 Төлбөртэй тусламж үйлчилгээний талаарх мэдээллийг бүсийн оношилгоо эмчилгээний төвийн цахим хаяг болон амбулаторийн хэсэгт ил тод байршуулна.

6.2 Аж ахуй нэгж байгууллага төлбөртэй тусламж үйлчилгээ авах гэж байгаа бол поликлиникийн эрхлэгчтэй , иргэн төлбөртэй тусламж үйлчилгээ авах гэж байгаа бол цахим бүртгэлийн ажилтан, хөтөчтэй холбогдоно.

6.3 Төлбөртэй тусламж үйлчилгээ үзүүлэгч нь тушаалын 3-р хавсралтанд заасан маягт хуудсыг үнэн зөв хөтөлж кассруу илгээнэ. Касс уг баримтыг хураан авч мөнгийг тушаалган үйлчлүүлэгчид ebarimt олгоно.

6.4 Ажлын бус цагаар төлбөртэй тусламж үзүүлэхэд байгууллагын төрийн сангийн 100100020006, хаан банкны 5564390740 дансанд төлбөрийг тушаалган дараа эхний ажлын өдөр ebarimt олгоно. Гүйлгээний утга дээр тусламж үйлчилгээ авсан үзүүлсэн хүний нэр, тусламж үйлчилгээний нэр, кодыг бичсэн байна.

## ДОЛОО. ТӨЛБӨРТЭЙ БОЛОН НЭМЭЛТ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОЛСОН ОРЛОГЫН БҮРТГЭЛ, ЗАРЦУУЛАЛТ

7.1 Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь төлбөртэй болон нэмэлт тусламж, үйлчилгээний орлого, зарцуулалтыг бодитой төлөвлөж, жил бүрийн төсөвтөө тусгана.

7.2 Тухайн жилийн төсөвт тусгагдаагүй, шинээр үүссэн нөхцөл байдлын улмаас бий болсон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журмаар зохицуулна.

7.3 Төлбөртэй болон нэмэлт тусламж, үйлчилгээнээс олсон орлого нь Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвийн өөрийн үйл ажиллагааны орлогод бүртгэгдэнэ.

7.4 Тус төвөөс үзүүлэх төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээний төлбөрийг цахим бүртгэлийн хэсэг дэх кассанд тушаалгаж баримт олгоно.

7.5 Төлбөртэй болон нэмэлт тусламж, үйлчилгээнээс олсон орлогыг байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэн төрийн сан дахь өөрийн харилцах дансанд төвлөрүүлнэ.

7.6 Тус төв нь иргэнд төлбөр төлсөн баримтыг заавал олгох бөгөөд уг баримтанд тасаг алба, эмчийн нэр, үйлчлүүлэгчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.

7.7 Төлбөртэй болон нэмэлт тусламж, үйлчилгээний орлогыг тухайн үйлчилгээг үзүүлэхэд оролцсон эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, засвар үйлчилгээ хийхтэй холбоотой гарах зардалд зарцуулна.

7.7.1 Эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал - 10%

7.7.2 Үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн ажилтны урамшуулал цалин-40%

7.7.3 Өөрийн орлого бүрдүүлэлтэд- 20%

7.7.4 Багаж тоног төхөөрөмж худалдан авах болон тэдгээрийн засвар үйлчилгээний зардал -20%

7.7.5 Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд-10%

## НАЙМ. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

8.1 Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан төлбөрийн жишиг хэмжээнээс хэтэрсэн төлбөр нэхэмжлэх

8.2 Эрүүл мэндийн байгууллагын ажлын үндсэн цагт багтаан үзүүлэх боломжтой тусламж үйлчилгээг ажлын бус цагаар, эсвэл бусад хэлбэрээр тохиролцон төлбөртэй үзүүлэх, үзүүлэхээр үйлчлүүлэгчийг ятгах

8.3 Үйлчлүүлэгчээс байгууллагын данснаас өөр дансанд болон бэлнээр үйлчилгээний төлбөр авахыг завдах

## ЕС. ХЯНАЛТ

9.1 Төлбөртэй болон нэмэлт тусламж, үйлчилгээ ньбайгууллагын үндсэн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх, байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй байх чиглэлээр төлбөрт үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүргийг захирал, дэд захирлууд, тасаг албадын дарга нар хүлээнэ.

9.2 Төлбөртэй болон нэмэлт тусламж, үйлчилгээний орлого, зарлагын гүйцэтгэл болон төлбөрт үйлчилгээний хэрэгжилтийн байдалд, тус төвийн гүйцэтгэлийн удирдлага дотоод аудитын баг улирал бүр, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргана.

9.3 Төлбөртэй болон нэмэлт тусламж үйлчилгээний талаарх иргэдийн өргөдөл, санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал, төлбөрт үйлчилгээний орлогын зарцуулалтынталаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн дэд захирлууд тасаг албадын дарга нар хангаж ажиллана.

## АРАВ . ХАРИУЦЛАГА

10.1 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтан, эмч, эрүүл мэндийн ажилтанд байгууллагын дотоод журам болон хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

10.2 Энэхүү журмыг зөрчиж иргэн, албан байгууллагаас нэмэгдэл төлбөр авсан, төлбөрийг бэлнээр авч ашигласан нь нотлогдсон тохиолдолд төлбөр төлөгчийн төлбөрийг нөхөн гаргуулж дотоод журам болон хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ тооцно.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн
Захирлын 2025 оны 11 дугаар сарын 12-ний
өдрийн А/43 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# АРВАН НЭГ. БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВӨӨС ИРГЭНД ҮЗҮҮЛЭХ ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ЖИШИГ ХЭМЖЭЭ

## 11.1 Хавдрын маркер илрүүлэх шинжилгээ

| № | Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт | Тусламж, үйлчилгээний нэр төрөл | Код | Төлбөрийн жишиг хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | Бусад тусламж: Хавдрын маркер илрүүлэх шинжилгээ | AFP-Элэгний хавдрын шинжилгээ | 10101001 | 20,000 |
| 2 | | PSA-Түрүү булчирхайн хавдрын шинжилгээ | 10101002 | 20,000 |
| 3 | | CEA -Бүдүүн шулуун гэдэс, ходоодны хавдрын шинжилгээ | 10101003 | 20,000 |
| 4 | | CA 72-4 Хоол боловсруулах эрхтэний болон эмэгтэйчүүдийн хавдрын шинжилгээ | 10101004 | 20,000 |
| 5 | | CA 125 Өндгөвчний хавдрын шинжилгээ | 10101005 | 20,000 |
| 6 | | CA 153 Хөхний хавдрын шинжилгээ | 10101006 | 20,000 |
| 7 | | NSE Уушгины хавдрын шинжилгээ | 10101007 | 25,000 |
| 8 | | Pepsinogen 1 Ходоодны хатингаршил | 10101008 | 30,000 |

## 11.2 Арьс харшлын өвчний оношилгоо

| № | Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт | Тусламж, үйлчилгээний нэр төрөл | Код | Төлбөрийн жишиг хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | Лабораторийн шинжилгээ | Амьсгалын замын харшлын сорил 10 төрөл | 10201001 | 40,000 |
| 2 | Лабораторийн шинжилгээ | Хүнсний харшлын сорил 10 төрөл | 10201002 | 40,000 |
| 3 | Лабораторийн шинжилгээ | Харшлын сорил цусанд өвөрмөц IgE үзэх | 10201003 | 40,000 |

## 11.3 Оношилгооны ажилбар, хэмжилт, сорил, шинжилгээ

| № | **Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт** | **Тусламж, үйлчилгээний нэр төрөл** | **Код** | **Төлбөрийн жишиг хэмжээ** |
|---|---|---|---|---|
| 1 | Багажийн шинжилгээ | Артерийн даралтын 24 цагийн хяналт | 10301001 | 48,000 |
| 2 | Багажийн шинжилгээ | Ачаалалтай зүрхний цахилгаан бичлэг | 10301002 | 30,000 |
| 3 | Багажийн шинжилгээ | 24 цагийн холтер зүрхний цахилгаан бичлэг | 10301003 | 80,000 |
| 4 | Багажийн шинжилгээ | Зүрхний цахилгаан бичлэг | 10301004 | 10,000 |
| 5 | Багажийн шинжилгээ | Умайн хөндийн дуран | 10301005 | 30,000 |
| 6 | Багажийн шинжилгээ | Умайн хүзүүний дуран (Кольпоскопи) | 10301006 | 30,000 |
| 7 | Багажийн шинжилгээ | Ургийн зүрхний цахилгаан бичлэг | 10301007 | 30,000 |
| 8 | Бүх төрлийн уян дурангийн оношилгоо | Унтуулгатай уян дуран (Бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой ходоод, төвөнх) | 10301008 | 100,000 |
| 9 | Бүх төрлийн уян дурангийн оношилгоо | Уян дуран (Бүдүүн гэдэс, уушги, улаан хоолой ходоод, төвөнх) | 10301009 | 70,000 |
| 10 | Бүх төрлийн уян дурангийн оношилгоо | Хатуу дуран (хамар, чих, арьс, вүүдийн ламп) | 10301010 | 30,000 |
| 11 | Бүх төрлийн хэт авиан оношилгоо | Хэт авиа ( бамбай булчирхай, хөх, захын судас, нүд, хэвлий, нярайн түнх, нярайн зулай, цээж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрхтэн, гүрээний артери, зөөлөн эд, шөрмөс, үе) | 10301011 | 20,000 |
| 12 | Бүх төрлийн хэт авиан оношилгоо | Зүрхний хэт авиан шинжилгээ | 10301012 | 50,000 |
| 13 | Бүх төрлийн хэт авиан оношилгоо | Хэт авиан хяналтанд хийх нарийн зүүний хатгалт, биопси (Бамбай, хөх, зөөлөн эд) | 10301013 | 80,000 |
| 14 | Бүх төрлийн хэт авиан оношилгоо | Хэт авиан хяналтанд хийх цээж хэвлийн хатгалт | 10301014 | 50,000 |
| 15 | Гадаад амьсгалын | Спирограмм | 10301015 | 16,000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааны шинжилгээ | | | |
| 16 | Дуу авианы шинжилгээ | Ларингоскопия шинжилгээ | 10301016 | 22,000 |
| 17 | Бүх төрлийн компьютерт томографын оношилгоо | Нэг байрлалд хийх тодосгогчгүй компьютерт томограф (Толгой, хамар дайвар, ухархай, чамархай, хэвлий, бөөр шээсний зам, цээж, зүрхний титэм судас, бага аарцаг, дээд мөч, доод мөч, хүзүү, сээр, ууц) | 10301017 | 90,000 |
| 18 | Бүх төрлийн компьютерт томографын оношилгоо | Нэг байрлалд хийх тодосгогчтой компьютерт томограф (Толгой, хамар дайвар, ухархай, чамархай, хэвлий, бөөр шээсний зам, цээж, зүрхний титэм судас, бага аарцаг, дээд мөч, доод мөч, хүзүү, сээр, ууц) | 10301018 | 240,000 |
| 19 | Бүх төрлийн компьютерт томографын оношилгоо | Олон байрлалд хийх тодосгогчгүй компьютерт томограф (Цээж хэвлий, бүтэн нуруу, политраума, толгой хүзүү) | 10301019 | 120,000 |
| 20 | Бүх төрлийн компьютерт томографын оношилгоо | Олон байрлалд хийх тодосгогчтой компьютер томограф (Цээж хэвлий, бүтэн нуруу, политраума, толгой хүзүү) | 10301020 | 270,000 |
| 21 | Рентген оношилгоо | Бөөр, шээс ялгаруулах замын тодосгогчтой шинжилгээ (Бөөрний ялгаруулах үйл ажиллагаа, гистеросалпингографи, шодойн хөндийлөг бие, шээдэг сув, шээлгүүр өгсүүлэх, уруудуулах, цистография) | 10301021 | 45,000 |
| 22 | Рентген оношилгоо | Бүх төрлийн рентген оношилгоо 1 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү) | 10301022 | 20,000 |
| 23 | Рентген оношилгоо | Бүх төрлийн рентген оношилгоо 2 байрлал (Гавал, хамар, цээж, хүзүү, ууц, нуруу, ахар сүүл, сээр, дээд мөч, доод мөч, аарцаг, аденойд, дал, өвчүү, ухархай, хавирга, чих, эгэм, эрүү) | 10301023 | 20,000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 24 | Рентген оношилгоо | Маммографи (1 хөх, 2 байрлал) | 10301024 | 20,000 |
| 25 | Рентген оношилгоо | Маммографи (2 хөх, 2 байрлал) | 10301025 | 35,000 |
| 26 | Рентген оношилгоо | Рентген харалт (Цээж, хэвлий) | 10301026 | 10,000 |
| 27 | Рентген оношилгоо | Рентгений хяналтанд хийх ажилбар | 10301027 | 60,000 |
| 28 | Рентген оношилгоо | Хоол боловсруулах замын баритай шинжилгээ (Улаан хоолой, ходоод, дээд гэдэс, бүдүүн шулуун гэдэс) | 10301028 | 60,000 |
| 29 | Рентген оношилгоо | Ясны сийрэгжилтийн шинжилгээ (Остеоденситометри) | 10301029 | 33,000 |
| 30 | Рентген оношилгоо | Шүдний хажуугийн рентгэн зураг | 10301030 | 30.000 |
| 31 | Рентген оношилгоо КТГ | Хэсгийн компьютер томографи CBCT | 10301031 | 30.000 |
| 32 | Тодосгогчтой КТГ | Тодосгогч бодисны үнэ | 10301032 | Нийлүүлэгч компанийн бодит өртөгөөр |
| 33 | Ангиогрофи | Тодосгогч бодисны үнэ | 10301033 | |
| 34 | Тархины цахилгаан бичлэг | Нойрны олон үйлдэлт бичлэг (PSG) | 10301034 | 250,000 |
| 35 | Чихний эмгэг, сонсголын шинжилгээ | Сонсголын тусгай сорилууд | 10301037 | 20,000 |
| 36 | Чихний эмгэг, сонсголын шинжилгээ | Тимпанометр | 10301038 | 20,000 |

## 11.4 Шүд амны хөндийн өвчний ерөнхий үзлэг, оношилгоо, эмчилгээ

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Амны хөндийн үйлчилгээ | Бүх шүдний өнгөр чулуу цэвэрлэх | 10401001 | 50,000 |
| 2 | Амны хөндийн үйлчилгээ | Голонцортой шүд хийх, голонцор зоож ломбодох | 10401002 | 80,000 |
| 3 | Амны хөндийн үйлчилгээ | Силант хийх | 10401003 | 15,000 |
| 4 | Амны хөндийн үйлчилгээ | Тулгуур эдийн хагалгаа хийх (1 шүд) | 10401004 | 60,000 |
| 5 | Амны хөндийн үйлчилгээ | Түүшин засах | 10401005 | 60,000 |
| 6 | Амны хөндийн үйлчилгээ | Хөндлөн байрлалтай араа авах | 10401006 | 160,000 |
| | | Байнгын шүд авах | 10401007 | 30,000 |
| | | Сүүн шүд авах | 10401008 | 20,000 |
| | | Буруу байрлалтай хүндрэлтэй шүд авч оёдол тавих | 10401009 | 80,000 |
| 7 | Амны хөндийн үйлчилгээ | Хэл, уруулын хөвч уртасгах | 10401010 | 70,000 |
| 8 | Амны хөндийн үйлчилгээ | Шүдний гаралтай ясны хальсны идээт үрэвсэл нээх | 10401011 | 30,000 |
| 9 | Амны хөндийн үйлчилгээ | Шүдний паалан тавих | 10401012 | 40,000 |
| 10 | Амны хөндийн үйлчилгээ | Ясны болон шүлсний булчирхайн үйланхай авах | 10401013 | 100,000 |
| 11 | Амны хөндийн бусад үйлчилгээ | Шүд цайруулах эмчилгээ бүрэн | 10401014 | 150,000 |
| 12 | Амны хөндийн бусад үйлчилгээ | Шүдний эмчилгээ | 10401015 | 59,000 |
| 13 | Амны хөндийн бусад үйлчилгээ | Хагас мултарсан болон бүрэн мултарсан шүдэнд чиг тавих | 10401016 | 50,000 |
| 14 | Амны хөндийн бусад үйлчилгээ | Буйл тайрах томорсон буйл авах | 10401017 | 30,000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 15 | Амны хөндийн бусад үйлчилгээ | Шүдний хар цагаан түрхлэг хийх | 10401018 | 20,000 |

### 11.5 Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Арьсны хоргүй хавдар, үү, ургацаг авах /байрлал хэмжээнээс хамаарч олон тооны жижиг хэмжээтэй бол/ | 11201001 | 80,000 |
| 2 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Батга цэвэрлэх | 11201002 | 25,000 |
| 3 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Даавар (Тууралтан дотор хийх даавруud) | 11201003 | 30,000 |
| 4 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Доод зовхины гадагш шамралтыг засах | 11201004 | 150,000 |
| 5 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Доод зовхины гадагш шамралтыг засах /Хөгшрөлтийн болон бусад шалтгаант/ | 11201005 | 250,000 |
| 6 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Доод зовхины урвалт засах | 11201006 | 50,000 |
| 7 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын | Доод зовхины урвалтын дахилтыг засах | 11201017 | 150,000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тусламж, үйлчилгээ | | | |
| 8 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Наснаас хамааралтай дээд зовхины арьсны илүүдэл авах /блефаро-халазис/ | 11201018 | 150,000 |
| 9 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Нүдний мах хусах | 11201019 | 100,000 |
| 10 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Нүдний салстын нөхөөс хийх мэс засал | 11201010 | 150,000 |
| 11 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Нүдэнд давхраа хийх | 11201011 | 250,000 |
| 12 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Нүдний салстын нөхөөс хийх | 11201012 | 150000 |
| 13 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Нүдэнд давхраа хийх | 11201013 | 300000 |
| 14 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | НД ЙАГ лазер | 11201014 | 100000 |
| 15 | Арьс, салстын эмчилгээний | Сэтэрхий чих оёх /2 тал/ | 11201015 | 50,000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | гоо заслын тусламж, бусад үйлчилгээ | | | |
| 16 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, бусад үйлчилгээ | Том хэмжээтэй үү, ургацаг авах | 11201016 | 30,000 |
| 17 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, бусад үйлчилгээ | Халдварт нялаахай / гараар түүх / | 11201017 | 20,000 |
| 18 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Чихний дэлдэн засах /1 тал/ | 11201018 | 120,000 |
| 19 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ | Хамар өндөрлөх /имплант тавих / | 11201019 | 250000 |
| 20 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, бусад үйлчилгээ | Хамрын шинэ хугарал засах | 11201020 | 100000 |
| 21 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, бусад үйлчилгээ | Цус шүүх эмчилгээ | 11201021 | 50,000 |
| 22 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын | Хатиг буглаа нээх | 11201022 | 30,000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тусламж, үйлчилгээ | | | |
| 23 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, бусад үйлчилгээ | Сорви цэгцлэх ,засах , зөөлрүүлэх тариа хийх | 11201023 | 40000 |
| 24 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, бусад үйлчилгээ | Хамрын судас түлж цус тогтоох | 11201024 | 30000 |
| 25 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, бусад үйлчилгээ | Чих цоолох /нэг чих / | 11201024 | 10,000 |
| 26 | Арьс, салстын эмчилгээний гоо заслын тусламж, бусад үйлчилгээ | Захын харааны талбайн шинжилгээ | 11201025 | 30,000 |

## 11.6 Үргүйдлийн эмгэгийн үзлэг, оношилгоо, эмчилгээ, хяналт

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Үргүйдлийн эмгэгийн үзлэг, оношилгоо, эмчилгээ, хяналт | Эр бэлгийн эсийг угааж умайн хөндийд цацах ажилбар | 10601001 | 375000 |
| 2 | Үргүйдлийн эмгэгийн үзлэг, оношилгоо, эмчилгээ, хяналт | Өндгөвчийг зөөлөн сэдээх протокол эмчилгээ / эстрогены рецепторт хориг үүсгэгч эм эсвэл ароматаза ингибитор эм, гонадотропин даавар, гонадотропины антагонист, хорионы гонадотропин даавар | 10601002 | 1650000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Үргүйдлийн эмгэгийн үзлэг, оношилгоо, эмчилгээ, хяналт | Үрийн шингэний ерөнхий шинжилгээ | 10601013 | 50,000 |
| 4 | Жирэмсний эрт үеийн үр хөндөлт (12 долоо хоног хүртэлх) /эмнэлгийн заалтаар хийх үр хөндөлт хамаарахгүй/ | Гар соруурын аргаар ажилбар хийх (унтуулгагүй) | 10701004 | 75,000 |
| 5 | Жирэмсний эрт үеийн үр хөндөлт (12 долоо хоног хүртэлх) /эмнэлгийн заалтаар хийх үр хөндөлт хамаарахгүй/ | Гар соруурын аргаар ажилбар хийх (унтуулгатай) | 10701005 | 95,000 |
| 6 | Жирэмсний эрт үеийн үр хөндөлт (12 долоо хоног хүртэлх) /эмнэлгийн заалтаар хийх үр хөндөлт хамаарахгүй/ | Эмийн аргаар үр хөндөх | 10701006 | 50,000 |

## 11.7 Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлстэй холбоотой тусламж, үйлчилгээ

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө | Аж ахуй нэгж, байгууллагын захиалгаар зохион байгуулсан багцын урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ | 11101001 | Гэрээний үнийн дүнгээр |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө | Буу галт зэвсэг эзэмших сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт гаргах | 11101002 | 20,000 |
| 3 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө | Гадаад улсад явах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах | 11101003 | 80,000 |
| 4 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө | Гэр бүл болох, хүүхэд үрчлүүлэх зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах | 11101004 | 45,000 |
| 5 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө | Ажил сургуульд орох зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах | 11101005 | 60,000 |
| 6 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт гаргах үзлэг, зөвлөгөө | Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтан, ажиллагсад | 11101006 | 50,000 |
| 7 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн дүгнэлт | Ус хангагч байгууллагын ус түгээгч, усан сан ариутгагч, усны машины жолооч | 11101007 | 50,000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | гаргах үзлэг, зөвлөгөө | | | |
